



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 06 24
оны сарын өдөр

Дугаар 229

Улаанбаатар хот

Г Монгол Улс, Оросын Холбооны
Улсын хооронд дипломат харилцааны
тогтоосны 100 жилийн ойг тэмдэглэл
өнгөрүүлэх арга хэмжээний
хүрээнд хамтран ажиллах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх
хэсэг, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.2 дахь
заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан Монгол, Оросын
харилцааны 100 жилийн түүхийн тухай Гадаад харилцааны яам, Олон улс судлалын
хүрээлэнгээс эрхлэн бэлтгэж буй ном, сэтгүүлийн зардал 193.0 /нэг зуун ерин
гурван/ сая төгрөгийг холбогдох эх үүсвэрээс гарган санхүүжүүлэхийг “Эрдэнэт
үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд
зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн
удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001231

ТӨБЗГ тогтоол-/2021